

## ХЯТАД-ЭНЭТХЭГИЙН ХАРИЛЦАА: ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ

*Ц.Батбаяр\**

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зябао 2005 оны 4 дүгээр сарын 5-12-ны өдрүүдэд Пакистан, Бангладеш, Шри Ланка, Энэтхэг гэсэн Өмнөд Азийн 4 орноор 8 хоног айлчлав. Хятад-Энэтхэгийн хилийн асуудлаархи ээлжит уулзалт Ерөнхий сайдын айлчлалын өмнө болж хоёр тал хилийн асуудлуудыг зохицуулах улс төрийн үндсэн зарчмуудыг харилцан тохиролцов. Пакистанд болсон Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээний Сайд нарын 4 дүгээр уулзалтанд Вэнь Зябао оролцож үг хэлэв. Хятад-Бангладешийн хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойн арга хэмжээнүүдэд тэрээр мөн оролцов.

### **Хятад-Энэтхэгийн стратегийн түншлэл, хилийн асуудал**

Ерөнхий сайд Вэнь Зябао 4 дүгээр сарын 9-12-ны өдрүүдэд Энэтхэг улсад айлчлав. Тэрээр айлчлалаа Энэтхэгийн мэдээллийн технологийн төв болох Бангалор хотоос эхэлж 4 дүгээр сарын 11-ний өдөр Дели хотноо Энэтхэгийн Ерөнхий сайдтай яриа хэлэлцээ хийж, Энэтхэгийн Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгч нартай ёслолын уулзалт хийснээс гадна Дели хотын Технологийн Их сургуульд зочилж, багшлах бүрэлдэхүүн, оюутнуудтай уулзалт хийв. Хоёр Ерөнхий сайдын яриа хэлэлцээ 4 дүгээр сарын 11-ний өдөр 3 цаг гаруй үргэлжилж, хоёр талын харилцаа, олон улсын болон бүс нутгийн сонирхсон асуудлуудаар санал солилцсон байна. Айлчлалын үр дүнд хамтарсан мэдэгдэл гаргаснаас гадна 11 гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурсан байна.<sup>1</sup>

Хамтарсан мэдэгдэлд хоёр улс “энх тайван, хөгжил цэцэглэлтэд чиглэсэн стратегийн түншлэлийг” (Strategic and Cooperative Partnership for Peace and Prosperity) байгуулж байгаа тухай тунхаглажээ. Энэ нь хоёр орны харилцааны түвшин улс хоорондын түвшнээс халин гарч глобаль болон стратегийн шинэ түвшинд дэвшин гарсныг илэрхийлж байгаа ажээ. Стратегийн түншлэл нь мөн хоёр орны харилцаанд оршиж буй болон үүсэж болзошгүй маргаантай зөрчилтэй асуудлуудыг урьдчилан харж яриа хэлэлцээний замаар шийдвэрлэх боломжийг нээж байгаа гэж ажиглагчид тэмдэглэж байна. Стратегийн түншлэл нь цэргийн гэрээ буюу эвсэл байгуулна гэсэн үг бус харин дэлхий дахины томоохон үйл явдлуудыг хамтран ажиглаж, хамтран үнэлэлт дүгнэлт өгөх бололцоог олгох болно гэж Энэтхэгийн тал мэдэгдэв.

\*Ц.Батбаяр - доктор (Sc.D)

БНХАУ Энэтхэг улстай Гадаад хэргийн дэд сайд нарын түвшинд анхны “стратегийн зөвлөлдөх уулзалт”-ыг 2005 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Нью Дели хотод хийсэн билээ. Хятадын талыг ГЯЯ-ны дэд сайд У Давей, Энэтхэгийн талыг Энэтхэгийн ГЯЯ-ны дэд сайд (Foreign Secretary Shyam Saran) тэргүүлсэн.<sup>2</sup> Стратегийн зөвлөлдөх уулзалт нь хоёр талын харилцааны хүрээг өргөжүүлж, глобаль болон бүс нутгийн аюулгүй байдлын асуудлуудаар санал солилцох зорилготой. Үүнийг цаашид байнгын механизм болгохоор Ерөнхий сайд нар тохирчээ.

Айлчлалын гол үр дүнг хилийн асуудлыг шийдвэрлэх зарчмууд болон улс төрийн гол гол нөхцлүүдийг тохиролцсон явдал (Agreement on the Political parameters and Guiding principles for the settlement of the India-China boundary question) гэж Энэтхэгийн Ерөнхий сайд дүгнэсэн байна. Энэтхэгийн Ерөнхий сайд Важпайн 2003 оны 6 дугаар сард БНХАУ-д хийсэн айлчлалын үеэр хоёр тал хилийн асуудлаар дээд тушаалын тусгай төлөөлөгчдийг (Special Representatives) томилох тухай тохиролцсон билээ. Энэхүү тохиролцооны дагуу хийсэн удаа дараагийн яриа хэлэлцээний дүнд дээрх хэлэлцээрийг байгуулсан байна. Хоёр орны “урт удаан хугацааны эрх ашиг”-ийг харгалзан үзсэний үндсэн дээр хилийн асуудлаар “улс төрийн шийдэл”-д хүрэх тухай Хэлэлцээрт тусгажээ. Хилийн асуудлаар хоёр тал 24 жил уйгагүй ажилласны үр дүн гэж Энэтхэгийн ЭСЯ-ны зөвлөх Бээжинд хийсэн мэдээлэх уулзалт дээр мэдэгдэв.<sup>3</sup>

Хилийн зурвасыг тодорхойлох (Line of actual control) ажлын хэсгийн ажлыг үргэлжлүүлэхийн хамт хилийн шугамыг заасан хоёр талын нарийвчилсан газрын зургуудыг солилцоно. Хоёр орны хилийн бүс нутагт итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх тухай протоколд мөн хоёр тал гарын үсэг зуржээ. Хятадын тал Сиккимыг “Энэтхэгийн салшгүй хэсэг” хэмээн хүлээн зөвшөөрч Сиккимыг Энэтхэгийн газар нутагт багтаан оруулж зурсан газрын зургийг Энэтхэгийн талд гардуулжээ. Энэтхэгийн тал Төвдийн ӨЗО-ныг “БНХАУ-ын хэсэг” гэдгийг дахин нотолж Энэтхэгт оршин сууж буй төвдүүдийг Хятадын эсрэг улс төрийн үйл ажиллагаанд оролцохыг зөвшөөрөхгүй гэдгээ Хамтарсан мэдэгдэлд илэрхийлжээ.<sup>4</sup>

Хоёр тал НҮБ-ын өөрчлөн шинэчлэлтийг бүх талыг хамарсан, иж бүрэн байх, хөгжиж буй орнуудын төлөөллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байх тухай санал нэгдсэн байна. Энэтхэгийн тал “НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн болох хүсэл санаагаа” давтан илэрхийлсэн бөгөөд Хятадын тал “НҮБ-ын болон олон улсын үйл хэрэгт идэвхитэй үүрэг гүйцэтгэх гэсэн Энэтхэгийн хүслийг ойлгон дэмжиж” байгаагаа мэдэгдсэн байна. Энэтхэгийн “The Asian Age” сонинд бичсэнээр

Пакистаны тал НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийг өргөтгөх “В” загварыг дэмжихийг хүсэж БНХАУ-д шахалт үзүүлж буй бөгөөд харин Энэтхэг “А” загварыг сонгож дэмжлэг үзүүлэхийг БНХАУ-аас хүссэн байна.<sup>5</sup>

### **Хятад-Энэтхэгийн эдийн засаг, худалдаа**

Айлчлалын үеэр Хятад-Энэтхэгийн худалдаа, эдийн засгийн иж бүрэн хамтын ажиллагааны асуудлаарх хамтарсан судалгааны бүлгэм (Joint Study Group) илтгэлээ танилцуулсан байна. Энэхүү бүлгэмийг хоёр орны Худалдааны дэд сайд нар тэргүүлдэг бөгөөд 2004-2005 онд дөрвөн удаа ээлжлэн хуралдаж 7 бүлэгтэй илтгэлийг боловсруулжээ. Тус бүлгэм Төрийн Зөвлөлийн гишүүн Тан Зясюаний 2004 оны 10 дугаар сард Энэтхэгт айлчлахдаа дэвшүүлсэн хоёр орны хооронд чөлөөт худалдааны дэглэм байгуулах асуудлыг судлан үзээд тодорхой зөвлөмжүүд гаргажээ.<sup>6</sup>

Өнгөрсөн 2004 онд хоёр орны худалдаа 13,6 тэрбум ам.долларт хүрсэн байна. Гэвч энэ нь Хятадын нийт гадаад худалдааны зөвхөн 1 хувь, Энэтхэгийн нийт гадаад худалдааны 9 хувьтай тэнцэж байна. Иймд хоёр орны худалдааг 2008 онд 20 тэрбум, цаашдаа 30 тэрбум ам.долларт хүргэх зорилтыг дэвшүүлэн тавьжээ. Хятадын компаниуд Энэтхэгийн мэдээллийн технологи, программ хангамжийн салбарт хамтран ажиллах, Энэтхэгийн компаниуд Хятадын боловсруулах үйлдвэрийн салбарт олсон ололт туршлагаас суралцах сонирхолтой ажээ.

2005 оны эхний улиралд Энэтхэг-Хятадын худалдаа өмнөх оны мөн үеийнхээс 42,4 хувь өсөж 4,46 тэрбум ам.долларт хүрсэн байна. БНХАУ-ын ГЕГ-ын мэдээгээр Энэтхэгээс Хятадад гаргасан экспортын хэмжээ 2,72 тэрбум, Хятадаас Энэтхэгт оруулсан импорт 1,74 тэрбум ам.доллар болжээ. 2005 оны эхний улирлын экспорт болон импортын хэмжээ өнгөрсөн оны мөн үеийнхээс 28,3 болон 72 хувь тус тус өссөн байна.

### **Хүснэгт 1: Энэтхэг-Хятадын 2005 оны эхний улирлын худалдаа /сая ам.доллар/**

| Он, сар      | Энэтхэгийн экспорт | Энэтхэгийн импорт | Нийт     | Энэтхэгийн худалдааны баланс |
|--------------|--------------------|-------------------|----------|------------------------------|
| Jan-Mar 2005 | 2722.756           | 1738.997          | 4461.753 | +983.759                     |
| Jan-Mar 2004 | 2122.232           | 1011.348          | 3133.58  | +1110.884                    |
| % Change     | 28.3%              | 72%               | 42.4%    |                              |

*[Source: General Administration of Customs of the People's Republic of China]*

Хоёр орны хооронд чөлөөт худалдааг хөгжүүлэх үүднээс Бүс нутгийн худалдааны хэлэлцээрийг (Regional Trading Arrangement) боловсруулах зорилготой хамтарсан ажлын хэсгийг байгуулахаар тохиролцсон байна. Хятад-Энэтхэгийн хооронд гаалийн салбарт хамтран ажиллах Хэлэлцээр, иргэний агаарын тээврийн салбарт хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зуржээ. Банк санхүүгийн салбарт хоёр орны хооронд яриа хэлэлцээний суваг (Launch of the India-China Financial Dialogue) нээх тухай тохиролцоонд мөн хүрчээ.

### **Хэтийн төлөв**

БНХАУ өөрийгөө тойрсон хөрш орнуудтай энх тайвнаар зэрэгцэн орших, Энэтхэг, Вьетнам зэрэг орнуудтай хилийн асуудлыг урт хугацааны эрх ашгийн үүднээс тайван замаар шийдэх, Энэтхэгтэй харилцан ойлголцол, харилцан итгэлцлийг бэхжүүлэх зорилгоор “стратегийн түншлэл” байгуулахаар болов. Хил залгадаг орнуудаа “энх амгалан”, “баян чинээлэг” хөршүүд болгох бодлогын хүрээнд Өмнөд Азийн орнуудад БНХАУ-ын удирдлага айлчлав.

Энэтхэг болон Хятадын эдийн засаг эрчимтэй хөгжихийн хирээр тэдний хооронд үүсэж буй байгалийн нөөц, эрчим хүчний эх үүсвэрийн талаарх өрсөлдөөнийг намжаах, зохицуулах арга замыг эрэлхийлсэн айлчлал болсон гэж дүгнэх үндэстэй. Энэтхэг, Хятад аль аль нь эрчим хүчний эх үүсвэрээр баялаг Иран, Судан, Саудын Араб зэрэг орнуудтай ойртон түншлэх болов. Энэтхэгийн эрчим хүчний 3 компани хамтран Иранаас ирэх 25 жилд шингэрүүлсэн байгалийн хий худалдан авах тухай 40 тэрбум ам.долларын өртөгтэй хэлэлцээрт 2005 оны 1 дүгээр сард хоёр тал гарын үсэг зуржээ.<sup>7</sup> Иранаас Пакистанаар дамжуулан Энэтхэг рүү татахаар яригдаж буй газрын тос, байгалийн хийн хоолойнуудыг Хятад хүртэл тавих саналыг Энэтхэгийн тал дэвшүүлжээ.

Энэтхэг-Хятадын ойртолт дэлхий дахины болон бүс нутгийн стратегийн орчинд ямар нөлөө үзүүлэх тухай судлаач ажиглагчид анхаарч байна.<sup>8</sup>

- Хятад-Энэтхэгийн стратегийн түншлэл гүнзгийрэх, худалдаа өргөжих, банк санхүүгийн хамтын ажиллагаа өргөжих үйл явц АНУ, Японы хувьд ямар үр дагавар авчрах,

- Олон жилийн турш Пакистантай цэрэг, эдийн засгийн салбарт холбоотны түвшинд харьцаж ирсэн БНХАУ Энэтхэгтэй ойртох явцад Пакистан хэрхэн хандах, ямар бодлого явуулах,

- Энэтхэг, Япон, Герман, Бразил зэрэг 4 орон НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн гишүүн болохоор чармайж байгаа байдалд БНХАУ ямар сонголт хийх, Энэтхэгийг дэмжих, Японыг үл дэмжих байр сууриа Хятад улс хэрхэн зохицуулах,

- АСЕАН-ы орнуудтай хийж буй, Энэтхэгтэй хийхээр судалж буй БНХАУ-ын чөлөөт худалдааны хэлэлцээрүүд бүс нутгийн худалдаа, хөрөнгө оруулалтад ямар нөлөө үзүүлэх зэрэг асуултууд хариу хүлээж байгаагаас гадна

- Энэтхэг-Хятадын стратегийн зөвлөлдөөнийг тогтмолжуулж байнгын механизм болгох, Энэтхэгийг Зүүн Азийн дээд хэмжээний уулзалтад (East Asia Summit) урьж оролцуулах, Орос-Энэтхэг-Хятад 3 орны Гадаад хэргийн сайд нарын хэмжээнд уулзалт хийдэг механизмыг байнгын болгох зэрэг шинэ хандлагууд бий болов.

### ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. PM's Statement in the Lok Sabha on the visits of Chinese Premier and Pakistan President, April 20, 2005, New Delhi: <http://pmindia.nic.in/lpeech.asp?id=109>
2. People's Daily Online, January 24, 2005.
3. Press Briefing at the Embassy of India to China, 25 April, 2005.
4. China, India issue joint statement on establishing "strategic and cooperative partnership": [http://english.peopledaily.com.cn/200504/13/print20050413\\_180682.html](http://english.peopledaily.com.cn/200504/13/print20050413_180682.html)
5. India in a China-Japan spat, "The Asian Age": <http://www.iht.com/getina/files/239147.html>
6. Joint Study Group Report: <http://www.mea.gov.in>
7. India joins China in stepped-up thirst for oil, "The New York Times", February 18, 2005.
8. Commentary: What an India-China axis means for the rest of Asia: [http://www.iht.com/bin/print\\_ipub.php?file=/articles/2005/04/13/bloomberg/sxpeseek.php](http://www.iht.com/bin/print_ipub.php?file=/articles/2005/04/13/bloomberg/sxpeseek.php)